



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, буртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 40,126,882.00 (дөчин сая нэг зуун хорин зургаан мянга найман зуун наян хоёр) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 3 (гурав) ширхэг автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, харьяа байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.Нарангэрэл

000013

Төрийнөмчийн бодлого зохицуулалтын газрын  
2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн  
... дугаар толгоолын хавсралт

Байгаль орчин, аялал жуучлалын яамны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй, актлах дансаас хасах автомашинь жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зорилтуулт, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын анхны үнэ (төгрөгөөр)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл эртэг (төгрөгөөр)
1	УАЗ-22069033 Фургон, 2280 ХЭҮ, араУ 374100С0002171	2012/2012	280000	20,800,000.00	20,800,000.00	-

#### 1.Онон-балжийн байгалийн цогцолборг газрын хамгаалалтын захиргаа

1	УАЗ-22069033 Фургон, 2280 ХЭҮ, араУ 374100С0002171	2003/2003	245000	9,326,882.00	9,326,882.00	-
2	Мицубиси пажеро 35-56 УБА араУ V434227056	1992/19912	319000	10,000,000.00	10,000,000.00	-
	Нийт дүн			40,126,882.00 (дэвчин сая нэг зүүн хорин зураган мянга найман зүүн наян хоёр)		

#### 2.Хан хэntий улсын тусгай хамгааллтай газрын хамгаалалтын газрын захиргаа